



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 02 дугаар сарын 17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | 11 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН..... | 15 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 15 |
| 4.2 Материаллаг байдал | 15 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 16 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 16 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 16 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 17 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 18 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| НББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| БШУС | Боловсрол шинжлэх ухааны сайд |



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/61.

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль байгуулагдсаны 80 жилийн ой болж төгсөгчдөөс 6,516.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандивласныг бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны гүйцэтгэлийн

005020283

төлөвлөгөөнд 18 зорилт, 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Боловсролын ерөнхий газраас 98.0 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>52,146,984.20</u> | <u>85,008,406.20</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 34,195,582.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 00.00 | 34,195,582.00 |
| 3121 | Төгрөг | 00.00 | 34,195,582.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 34,195,582.00 |
| 33 | АВЛАГА | 9,242.00 | 439,907.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 9,242.00 | 439,907.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 52,137,742.20 | 50,372,917.20 |
| 351 | Түүхий эд материал | 4,620,000.00 | 3,240,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 35130 | Эм боох материал | 1,620,000.00 | 240,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 47,517,742.20 | 47,132,917.20 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,825,861.00 | 7,188,036.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 39,691,881.20 | 39,944,881.20 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>810,805,028.52</u> | <u>792,420,908.34</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 810,805,028.52 | 792,420,908.34 |
| 392 | Биет хөрөнгө | 791,281,028.52 | 772,896,908.34 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 858,547,377.00 | 858,547,377.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -215,648,753.20 | -246,723,532.28 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 234,480,879.91 | 277,808,489.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -152,996,244.23 | -169,649,794.82 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 95,787,235.10 | 95,787,235.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -61,550,472.33 | -71,533,872.88 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 46,741,537.12 | 46,741,537.12 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -29,572,998.45 | -33,572,998.41 |
| 39217 | Ном | 15,492,467.60 | 15,492,467.60 |
| 393 | Биет бус хөрөнгө | 19,524,000.00 | 19,524,000.00 |
| 39301 | Программ хангамж | 200,000.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,524,000.00 | 19,524,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>862,952,012.72</u> | <u>877,429,314.54</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>00.00</u> | <u>210,010.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 210,010.00 |
| 413 | Өглөг | 00.00 | 210,010.00 |
| 4136 | Бусад өглөг | 00.00 | 210,010.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 210,010.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>862,952,012.72</u> | <u>877,219,304.54</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 862,952,012.72 | 877,219,304.54 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 290,170,245.35 | 290,170,245.35 |

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБ-ын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|------------|--|------------------------------|------------------------------|
| 51101 | Өмч: - төрийн | 290,170,245.35 | 290,170,245.35 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 13,682,670.15 | 27,949,961.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 13,682,670.15 | 13,682,670.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 14,267,291.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 559,099,097.22 | 559,099,097.22 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>862,952,012.72</u> | <u>877,429,314.54</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 656,394,424.30 | 765,900,999.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 35,657,360.30 | 31,697,310.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 35,657,360.30 | 31,697,310.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 56,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 56,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 620,737,064.00 | 734,203,689.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 525,782,800.00 | 599,880,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 18,384,798.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,472,580.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,912,218.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 76,569,466.00 | 134,309,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 76,569,466.00 | 134,309,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 00.00 | 13,589.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 13,589.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 627,481,202.72 | 751,633,707.18 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 627,481,202.72 | 751,633,707.18 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 578,354,154.72 | 694,854,507.18 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 375,959,021.00 | 439,030,756.00 |
| 210101 | Үндсэн цалин | 319,361,693.00 | 314,294,443.00 |
| 210102 | Нэмэгдэл | 31,922,803.00 | 94,534,539.00 |
| 210104 | Урамшуулал | 24,674,525.00 | 5,492,889.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 24,708,885.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,350,700.00 | 54,167,835.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,563,900.00 | 36,725,826.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,190,200.00 | 4,269,184.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,542,500.00 | 3,401,910.18 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 631,700.00 | 848,136.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,422,400.00 | 8,922,777.55 |

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБ-ын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------------|-----------------------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 76,261,966.00 | 84,939,287.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,464,226.00 | 7,576,727.00 |
| 210302 | Түлш, халаалт | 72,648,340.00 | 77,362,560.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 149,400.00 | 00.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,631,761.00 | 5,166,590.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,734,700.00 | 2,602,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,766,500.00 | 2,564,590.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 835,861.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 72,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 405,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,817,700.00 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 8,894,450.00 | 27,254,424.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,803,700.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,831,850.00 | 27,254,424.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 258,900.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,195,575.00 | 1,551,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,195,575.00 | 1,551,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 350,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 350,000.00 | 00.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,756,718.00 | 3,355,760.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,016,718.00 | 56,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 3,299,060.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,953,963.72 | 79,388,855.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,194,200.00 | 12,922,285.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,944,000.00 | 4,754,840.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,815,763.72 | 61,711,730.18 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49,127,048.00 | 56,779,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,795,080.00 | 36,613,839.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,961,400.00 | 31,071,350.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,472,580.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 361,100.00 | 5,542,489.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 20,165,361.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 20,165,361.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 35,331,968.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,331,968.00 | 00.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>28,913,221.58</u> | <u>14,267,291.82</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>28,913,221.58</u> | <u>14,267,291.82</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>620,737,064.00</u> | <u>734,260,389.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 00.00 | 56,700.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 56,700.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 56,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 56,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 620,737,064.00 | 734,203,689.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 00.00 | 599,880,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 599,880,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 525,782,800.00 | 00.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 18,384,798.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,472,580.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,912,218.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 76,569,466.00 | 134,309,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 76,569,466.00 | 134,309,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 00.00 | 13,589.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 13,589.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>586,048,064.00</u> | <u>688,377,807.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 586,048,064.00 | 688,377,807.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 536,957,126.00 | 635,234,967.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 375,995,131.00 | 439,030,756.00 |
| 210101 | Үндсэн цалин | 319,284,550.00 | 314,294,443.00 |
| 210102 | Нэмэгдэл | 32,036,056.00 | 94,534,539.00 |
| 210104 | Урамшуулал | 24,674,525.00 | 5,492,889.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 24,708,885.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,350,700.00 | 54,598,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,563,900.00 | 37,156,491.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,190,200.00 | 4,269,184.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,542,500.00 | 3,401,910.18 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 631,700.00 | 848,136.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,422,400.00 | 8,922,777.55 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 75,569,466.00 | 84,939,287.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,008,826.00 | 7,576,727.00 |
| 210302 | Түлш, халаалт | 72,411,240.00 | 77,362,560.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 149,400.00 | 00.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,155,861.00 | 00.00 |

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБ-ын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 210401 | Бичиг хэрэг | 993,600.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,665,660.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,291,261.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 72,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 435,840.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,697,500.00 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 9,669,650.00 | 30,680,774.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,618,900.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,831,850.00 | 30,680,774.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,218,900.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,195,600.00 | 1,551,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,195,600.00 | 1,551,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 350,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 350,000.00 | 00.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,728,218.00 | 3,883,760.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,988,218.00 | 56,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 3,827,060.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,942,500.00 | 20,550,890.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,993,500.00 | 14,174,050.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,949,000.00 | 6,376,840.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49,090,938.00 | 53,142,840.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,758,970.00 | 32,977,479.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,961,400.00 | 27,645,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,472,580.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 324,990.00 | 5,332,479.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 35,331,968.00 | 20,165,361.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,331,968.00 | 20,165,361.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>34,689,000.00</u> | <u>45,882,582.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 34,689,000.00 | 11,687,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 34,689,000.00 | 11,687,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 34,689,000.00 | 11,687,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 34,689,000.00 | 11,687,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-34,689,000.00</u> | <u>-11,687,000.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 34,195,582.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 34,195,582.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-------|--|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 290,170,245.35 | 559,099,097.22 | 13,682,670.15 | 00.00 | 862,952,012.72 |
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 290,170,245.35 | 559,099,097.22 | 13,682,670.15 | 00.00 | 862,952,012.72 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 290,170,245.35 | 559,099,097.22 | 13,682,670.15 | 00.00 | 862,952,012.72 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 14,267,291.82 | 00.00 | 14,267,291.82 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 290,170,245.35 | 559,099,097.22 | 27,949,961.97 | 00.00 | 877,219,304.54 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|-----------------------|---|-----------------------|----------------|---------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 734,246,800.00 | 679,899,446.00 | 54,347,354.00 | 92.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 734,246,800.00 | 679,899,446.00 | 54,347,354.00 | 92.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 694,553,900.00 | 646,921,967.00 | 47,631,933.00 | 93.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 462,353,200.00 | 439,030,756.00 | 23,322,444.00 | 95.0 |
| 210101 | Үндсэн цалин | 332,234,200.00 | 314,294,443.00 | 17,939,757.00 | 94.6 |
| 210102 | Нэмэгдэл | 94,877,000.00 | 94,534,539.00 | 342,461.00 | 99.6 |
| 210104 | Урамшуулал | 10,104,500.00 | 5,492,889.00 | 4,611,611.00 | 54.4 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 25,137,500.00 | 24,708,885.00 | 428,615.00 | 98.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 57,630,600.00 | 54,598,500.00 | 3,032,100.00 | 94.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,188,800.00 | 37,156,491.03 | 2,032,308.97 | 94.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,610,500.00 | 4,269,184.47 | 341,315.53 | 92.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,688,400.00 | 3,401,910.18 | 286,489.82 | 92.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 922,100.00 | 848,136.77 | 73,963.23 | 92.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,220,800.00 | 8,922,777.55 | 298,022.45 | 96.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 104,640,000.00 | 84,939,287.00 | 19,700,713.00 | 81.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,328,000.00 | 7,576,727.00 | -2,248,727.00 | 142.2 |
| 210302 | Түлш, халаалт | 98,261,000.00 | 77,362,560.00 | 20,898,440.00 | 78.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,051,000.00 | 00.00 | 1,051,000.00 | 0.0 |
| 2105 | Нормативт зардал | 30,683,600.00 | 30,680,774.00 | 2,826.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 30,683,600.00 | 30,680,774.00 | 2,826.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,552,900.00 | 1,551,000.00 | 1,900.00 | 99.9 |

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБ-ын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|---------------|--|-----------------------|-----------------------|----------------------|--------------|
| 210604 | Урсгал засвар | 1,552,900.00 | 1,551,000.00 | 1,900.00 | 99.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,309,700.00 | 3,883,760.00 | 425,940.00 | 90.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 56,700.00 | 56,700.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,253,000.00 | 3,827,060.00 | 425,940.00 | 90.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33383900.00 | 32237890.00 | 1,146,010.00 | 96.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,004,500.00 | 25,861,050.00 | 1,143,450.00 | 95.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,379,400.00 | 6,376,840.00 | 2,560.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 39692900.00 | 32977479.00 | 6,715,421.00 | 83.1 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 39,692,900.00 | 32,977,479.00 | 6,715,421.00 | 83.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 34,164,000.00 | 27,645,000.00 | 6,519,000.00 | 80.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,528,900.00 | 5,332,479.00 | 196,421.00 | 96.4 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 734,246,800.00 | 714,081,439.00 | 20,165,361.00 | 97.3 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 599,880,900.00 | 599,880,900.00 | 0.00 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 599,880,900.00 | 599,880,900.00 | 0.00 | 100.0 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 134,309,200.00 | 114,143,839.00 | 20,165,361.00 | 85.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 134,309,200.00 | 114,143,839.00 | 20,165,361.00 | 85.0 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 56,700.00 | 56,700.00 | 0.00 | 100.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 56,700.00 | 56,700.00 | 0.00 | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 38.00 | 37.00 | 1.00 | 97.4 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21.00 | 20.00 | 1.00 | 95.2 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 | 0.00 | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 38.00 | 37.00 | 1.00 | 97.4 |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 21.00 | 20.00 | 1.00 | 95.2 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11.00 | 11.00 | 0.00 | 100.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 06.00 | 06.00 | 0.00 | 100.0 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу боловсролын үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд нийт 34 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, нийт 9 бүлэг, 221 сурагчтай, 2022 оны үйл ажиллагааны зардалд 734,246.8 мянган төгрөг батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн зорилго, зорилт, чиг үүрэг нь сурагч нэг бүрийг ёс зүйтэй, унших бичих ярих чадвараа хөгжүүлсэн, бие даасан, бүтээлч, эрүүл чийрэг иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үгийг дарга Б.Ууганбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Оюунгэрэл (2022.01.01-2022.04.30), Б.Баттөмөр (2022.05.01-2022.12.31) нар зурж, нярваар Б.Амарбаясгалан ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал,
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор цалингийн шатлал,
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 192 дүгээр тогтоолоор цалингийн шатлал,
- БШУС-ын 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А/122 тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ЕБС-ийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээ,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУС-ын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 2022 оны 1, 2, 3 дугаар улирлыг хамруулан шалгалт хийсэн харин санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх НББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 876,998.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 14,046.6 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|------------------|------------------|-----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 34,195.6 | - |
| Авлага | 9.2 | 439.9 | 430.7 |
| Бараа материал | 52,137.7 | 50,372.9 | (1,764.8) |
| Үндсэн хөрөнгө | 1,270,773.5 | 1,314,101.1 | 43,327.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | (459,968.5) | (521,680.2) | (61,711.1) |
| Нийт хөрөнгө | 862,952.0 | 877,429.3 | 14,447.3 |
| Өр төлбөр | - | 210.0 | 210.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 862,952.0 | 877,219.3 | 14,267.3 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 862,952.0 | 877,429.3 | 14,447.3 |

Дээрх хүснэгтээс харахад Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 34,195.6 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Тайлант оны эхэнд 9.2 мянган төгрөгийн ажилчдаас авах авлагатай, НДШ-ийн 430.7 мянган төгрөгийн авлага нэмэгдэж тайлант оны эцэст 439.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 50,372.9 мянган төгрөг болж өмнөх оноос 1,764.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 77,431.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 79,196.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,314,101.1 мянган төгрөг болж 73,327.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 11,687.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, төгсөгчдөөс хандиваар 6,516.6 мянга, Боловсролын ерөнхий газраас 25,124.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Тайлант оны эхэнд өр төлбөргүй, тайлант оны эцэст ажилтнуудад өгөх 210.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 14,447.3 мянган төгрөгөөр өсөж 877,429.3 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 766,968.3 мянган төгрөг, нийт зарлагыг 766,968.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 132,175.9 мянган төгрөгөөр бууруулж, 634,492.4 мянган төгрөгөөр анх баталсан байна. Тайлант хугацаанд нэг удаа тодотгол хийж 99,754.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 734,246.8 мянган төгрөг болгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 734,246.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 734,246.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 679,885.8 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 34,195.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| (мянган төгрөгөөр) | | | | | |
|--------------------|--------------------------------------|------------|-----------|----------|---------|
| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| Улсын төсөв | | | | | |
| | 71802 Ерөнхий боловсрол | 599,937.6 | 565,742.0 | 34,195.6 | 91.5 |
| 1 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 1,701.2 | 1,700.9 | 0.3 | 100.0 |
| 2 | 80312 Сургалт семинар | 850.6 | 760.0 | 90.6 | 89.3 |
| 3 | 80605 Эрүүл мэндийг дэмжих | 1,956.4 | 1,257.5 | 698.9 | 64.3 |
| 4 | 80801 Үдийн цай хөтөлбөр | 34,164.0 | 27,645.0 | 6,519.0 | 80.9 |
| 5 | 81806 Дотуур байрны үйлчилгээ | 47,223.7 | 44,998.3 | 2,225.4 | 95.3 |
| 6 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 11,990.0 | 11,687.0 | 303.0 | 97.5 |
| 7 | 81823 Боловсролын байгууллагын багш | 3,827.7 | 3,780.7 | 47.0 | 98.8 |
| 8 | 81834 Боловсролыг стандарт | 422,896.0 | 408,517.1 | 14,378.9 | 96.6 |
| 9 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 75,271.3 | 65,338.8 | 9,932.5 | 86.8 |
| 10 | 81848 Сурах бичгийн түрээс | 56.7 | 56.7 | 0 | 100.0 |
| Орон нутгийн төсөв | | | | | |
| | 71802 Ерөнхий боловсрол | 134,309.2 | 114,143.8 | 20,165.4 | 85.0 |
| 1 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 134,309.2 | 114,143.8 | 20,165.4 | 85.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 627,481.2 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 627,481.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,412.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,588.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20,165.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 1,143.5 мянга, нийт 21,308.8 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон, харин халаалтын зардлыг өмнөх оноос 4,951.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2020-2021 оны хичээлийн жилд цар тахалтай холбоотойгоор үнэ нэмэгдээгүй, төсөвтөө багтаан төлбөрийг төлснөөс шалтгаалсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 139 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй, 4 мэдээллийг байршуулаагүй байна.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 48,351.6 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн бэлтгэн нийлүүлэгч 9 байгууллагатай байгуулсан гэрээг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, дутуу мэдээлсэн 5 гүйлгээний 48,351.6 мянган төгрөгийн мэдээллийг байршуулж, цаашид мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст үнэн зөв дүнгээр байршуулж буйд тавих төсвийн шууд захирагчийн хяналтыг сайжруулах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 104.2 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 104.2 | 1 | 104.2 | 100 |
| Албан шаардлага | 1 | - | 1 | - | 100 |
| Зөвлөмж | 3 | 2,835.7 | 3 | 2,835.7 | 100 |
| Нийт дүн | 5 | 2,939.9 | 5 | 2,939.9 | 100 |

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тус байгууллагын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 27 тоот албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БСШУСС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар Үдийн цай хөтөлбөрийн зардал 6,519.0 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах

дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 430.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлд илүү төлсөн 430.6 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Аудитаар нийт 2,468.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 694.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1,774.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч ажиллалаа.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Боловсролын мэдээллийн технологийн төвөөс бүх сургууль цэцэрлэгийн интернэтийн төлбөрийг бүрэн төлсөн байхад тус байгууллага нь 2022 оны 4-8 дугаар сард интернэтийн төлбөрт 694.1 мянган төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Интернэтийн төлбөрт зориулалт бусаар зарцуулсан 694.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Нийгмийн даатгалын хэлтэст 2022 оны 7,8 дугаар сарын цалин түүнтэй адилтгах орлогыг 1,774.3 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 17.1.1 дэх "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст цалин түүнтэй адилтгах орлогыг 1,774.3 мянган төгрөгөөр илүү мэдээлснийг залруулж, тооцоо нийлж баталгаажуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---------------|-----|-----------------|-----|-----|-----|---------|-----|
| | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 48,351.6 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, мөн бэлтгэн нийлүүлэгч 9 байгууллагатай байгуулсан гэрээг байршуулаагүй байна. | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |

00000